

ҮНЭТ ЦААСНЫ ТӨЛБӨР ТООЦООГ Т+2 ГОРИМООР ГҮЙЦЭТГЭХ ЖУРАМ

НЭГДҮГЭЭР БҮЛЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

Нэгдүгээр зүйл. Нийтлэг үндэслэл

- 1.1. Энэхүү журмаар “Монголын Хөрөнгийн Бирж” ХК /цаашид “МХБ” гэх/ дээр арилжаалагдах үнэт цаасны төлбөр тооцоотой холбоотой “Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төв” ХХК /цаашид “ҮЦТХТ” гэх/ болон Төлбөр гүйцэтгэгч банк /цаашид “ТГБ” гэх/, үнэт цаасны компани /цаашид “ҮЦК” гэх/-ийн хооронд үүсэх харилцааг зохицуулна.
- 1.2. “ҮЦТХТ”-тэй гэрээ байгуулан оролцож буй этгээд энэхүү журмыг мөрдөх үүрэгтэй бөгөөд зөрчсөн тохиолдолд холбогдох хууль тогтоомж болон журамд заасны дагуу хариуцлага хүлээнэ.
- 1.3. Энэхүү журам нь үнэт цаасны төлбөр тооцоонд Т+2 горим хэрэгжиж эхлэх өдрөөс хүчин төгөлдөр болно.

Хоёрдугаар зүйл. Нэр томъёоны тайлбар

Энэхүү журамд орсон нэр томъёог дор дурьдсан утгаар ойлгоно:

- 2.1. “Арилжааны өдөр” гэж МХБ-ийн арилжаа явагдах өдрийг;
- 2.2. “Харилцагчийн данс” гэж “ҮЦТХТ”-д тухайн этгээдийн нэр дээр бүртгэлтэй дансыг;
- 2.3. “Үнэт цаасны компани” /цаашид “ҮЦК” гэх/ гэж Хорооноос олгосон тусгай зөвшөөрөл бүхий үнэт цаасны компанийг;
- 2.4. “Төлбөр гүйцэтгэх банк” /цаашид “ТГБ” гэх/ гэж Монголбанкнаас мөнгөн хөрөнгийн төлбөр гүйцэтгэх үйлчилгээ үзүүлэх тусгай зөвшөөрөлтэй “ҮЦТХТ” -ийн шалгуурыг хангасан арилжааны банкиг;
- 2.5. “Арилжаа” гэж МХБ-ийн электрон арилжааны системээр гүйцэтгэгдсэн үнэт цаас худалдах, худалдан авах хэлцлийг;
- 2.6. “Төлбөр гүйцэтгэх өдөр” гэж арилжаа хийгдсэний дараагийн 2 дахь арилжааны өдрийг;
- 2.7. “Төлбөр гүйцэтгэх” гэж энэхүү журамд заасны дагуу үнэт цаасны болон мөнгөн хөрөнгийн төлбөрийн гүйцэтгэлийг хангуулах;
- 2.8. “Төлбөрийн дагуу хийгх шилжүүлэг” (DVP) гэж зөвхөн мөнгөн төлбөр хийгдсэн нөхцөлд тухайн үнэт цаасны өмчлөх эрх шилжүүлэхийг;
- 2.9. “Төлбөрийн чадваргүй харилцагч” гэж Хорооны 2015 оны 67 дугаар тогтоолын 2-т зааснаар арилжааны банкин дахь харилцагчдын үнэт цаас худалдах, худалдан авах тусгай дансанд үнэт цаасны төлбөрийг 100 хувь урьдчилан байршуулаагүй этгээдийг;
- 2.10. “Бодит цаг” төлбөрийн даалгаврыг хүлээн авсан тухайн цагт нь хойшлуулалгүй, нэг бүрээр нь гүйцэтгэх боловсруулалтыг хэлнэ.

Гуравдугаар зүйл. Үйл ажиллагааны нийтлэг зарчим

- 3.1. МХБ нь хийгдсэн арилжааны хэлцэл бүрийн мэдээлэл бодит цагийн горимоор “ҮЦТХТ” -д шууд шилжигдэх бөгөөд арилжаа хийсэн өдрийн хэлцлийн тооцоог боловсруулж, тухайн өдрийн 14:30 цагт багтаан арилжааны шимтгэл бодогдсон төлбөр гүйцэтгэх мэдээг үүсгэнэ.

- 3.2. “ҮЦТХТ” нь төлбөр гүйцэтгэхдээ дараах зарчмыг үйл ажиллагаандаа мөрдөнө:
3.2.1. “ҮЦТХТ”-ийн төлбөр тооцоо гүйцэтгэх цаг нь ажлын өдрийн 9:10-16:25 цаг байна.
3.2.2. мөнгөн хөрөнгийн төлбөрийг зөвхөн төгрөгөөр гүйцэтгэнэ.
- 3.3. “ҮЦТХТ” нь үнэт цаасны төлбөрийн гүйцэтгэл буцаагдахгүй байх ба мөнгөн хөрөнгийн төлбөрийн гүйцэтгэлтэй зэрэг гүйцэтгэгдэж байх нөхцлийг бүрдүүлэхэд шаардлагатай бүхий л арга хэмжээг авч хэрэгжүүлнэ. Төлбөр гүйцэтгэх өдрийн 12:00 цагт үнэт цаасны өмчлөх эрхийг шилжүүлэн бүртгэсэн байна.

Дөрөвдүгээр зүйл. “ҮЦТХТ” -өөс гаргах мэдээлэл, шимтгэл

- 4.1. “ҮЦТХТ”-өөс харилцагчийн данстай холбоотой мэдээллийг дараах тохиолдолд гаргана:
- 4.1.1 холбогдох ҮЦК-ийн албан хүсэлт,
 - 4.1.2 төвлөрсөн хадгаламжид данстай харилцагчийн бичгээр ирүүлсэн хүсэлт,
 - 4.1.3 үнэт цаас гаргагчийн албан хүсэлт,
 - 4.1.4 шүүхийн албан шаардлага,
 - 4.1.5 Хорооны албан хүсэлт, Улсын байцаагчийн албан шаардлага,
 - 4.1.6 Монголбанкны албан хүсэлт,
 - 4.1.7 МХБ-ийн Хяналтын албаны албан хүсэлт.
- 4.2. “ҮЦТХТ” нь энэхүү журамд заасны дагуу ТГБ болон ҮЦК-д арилжааны төлбөрийн гүйцэтгэлтэй холбоотой мэдээ, мэдээллийг тус тус авах хэрэглэгчийн эрхийг олгоно.
- 4.3. Энэхүү журмын дагуу “ҮЦТХТ” -ийн ажил үйлчилгээтэй холбоотойгоор “ҮЦТХТ” -өөс шаардлагатай шинэ маягтыг гаргаж, түүнд нэмэлт өөрчлөлтийг оруулж болно.
- 4.4. “ҮЦТХТ” -өөс тухай бүр тогтоож, Хороо зөвшөөрснөөр харилцагч, бүртгэлтэй компани, ҮЦК, ТГБ болон “ҮЦТХТ” -ийн үйлчилгээ үзүүлсэн аливаа этгээдээс үйлчилгээний шимтгэл авч болно.
- 4.4.1 Банк хоорондын төлбөр тооцооны үйлчилгээний шимтгэлийг “Монгол банкны хүү, шимтгэлийн ерөнхий нөхцөл”-д заасны дагуу харилцагчийн данснаас гүйлгээ тутамд тооцож авна.
 - 4.4.2 Гүйлгээний шимтгэл, хураамжийг банк хоорондын зарлагын гүйлгээ тутмаас 500 төгрөгөөр тооцно.
 - 4.4.3 Харилцагчаас авах арилжааны шимтгэлийг тооцож, холбогдох байгууллагад шилжүүлнэ.

ХОЁРДУГААР БҮЛЭГ. МӨНГӨН ХӨРӨНГИЙН ТӨЛБӨР ГҮЙЦЭТГЭХ ТУХАЙ

Тавдугаар зүйл. Мөнгөн хөрөнгийн төлбөрийг гүйцэтгэх

- 5.1. МХБ нь ТГБ дахь ҮЦК-ийн дансны гүйлгээтэй холбоотой мэдээ болон оролцогч бүрийн гүйцэтгэх төлбөрийн дүнгийн мэдээг Т+0 өдрийн 14.30 цагт үүсгэнэ.
- 5.2. ТГБ нь “ҮЦТХТ” –ийн системээр гаргасан төлбөрийн хуваарийн дагуу төлбөрийг төлбөр тооцоо гүйцэтгэх өдрийн 10.00 цагаас өмнө Монголбанкн дахь “ҮЦТХТ” -ийн дансанд байршуулна.
- 5.3. “ҮЦТХТ” нь төлбөр гүйцэтгэх өдрийн 10.30 цагт төлбөрийн хуваарийн дагуу төлбөр гүйцэтгэх банк хоорондын гүйлгээг Монголбанкны банк сүлжээгээр дамжуулан гүйцэтгэнэ.

- 5.4. ТГБ дотор ҮЦК хооронд төлбөр гүйцэтгэх тохиолдолд зөвхөн шимтгэлийн төлбөрийг Монголбанк дахь “ҮЦТХТ” -ийн дансанд 10.00 цагаас өмнө байршуулсан байна.
- 5.5. ТГБ нь үнэт цаасны төлбөр гүйцэтгэхтэй холбоотойгоор “ҮЦТХТ” -өөс ирүүлсэн мэдээллийг зөвхөн үнэт цаасны арилжааны төлбөр гүйцэтгэхэд ашиглах ба тухайн мэдээллийг бусдад тараах болон өөр зорилгоор ашиглахыг хориглоно.
- 5.6. Үнэт цаас худалдан авагч нь ТГБ дахь өөрийн үнэт цаас худалдах, худалдан авах тусгай дансанд үнэт цаасны төлбөрийг 100 хувь урьдчилан байршуулах ба энэ нөхцлийг хангасан дансны үлдэгдлийг үндэслэн ҮЦК тэдгээрийн захиалгыг МХБ-ийн арилжааны системд оруулах үүрэгтэй.
- 5.7. Энэхүү журмаар зохицуулагдаагүй бусад харилцааг “ҮЦТХТ”-ийн бусад холбогдох журмаар зохицуулна.

ГУРАВДУГААР БҮЛЭГ. ТГБ БОЛОН ҮЦК-Д ТАВИГДАХ ШААРДЛАГА

Зургаадугаар зүйл. “ҮЦТХТ” -өөс ҮЦК, ТГБ-нд тавих шаардлага

- 6.1. “ҮЦТХТ” -д бүртгэлтэй харилцагчийн үнэт цаасны болон мөнгөн хөрөнгийн дансны гүйлгээ нь ҮЦК болон ТГБ-аар дамжин гүйцэтгэгдэнэ.
- 6.2. ҮЦК, ТГБ нь үнэт цаасны арилжааны төлбөрийг гүйцэтгэхийн тулд “ҮЦТХТ” -ийн дүрэм, журам, холбогдох маягтын дагуу “ҮЦТХТ” -д өргөдлөө ирүүлэх бөгөөд “ҮЦТХТ” нь шаардлага хангасан ТГБ болон ҮЦК-тай төлбөр гүйцэтгэх гурвалсан гэрээг байгуулсны үндсэн дээр хамтран ажиллана. Уг гэрээг байгуулснаар ҮЦК-ийн арилжаанд оролцох эрх нээгдэнэ.
- 6.3. “ҮЦТХТ” нь энэ журамд заасан шаардлага хангасан ҮЦК, ТГБ-ын жагсаалтыг өөрийн цахим хуудсанд байршуулна.
- 6.4. “ҮЦТХТ” нь ҮЦК болон ТГБ бүрт тусгайлсан таних код олгох ба уг кодыг гүйлгээний болон бусад зорилгоор ашиглана.
- 6.5. “ҮЦТХТ” нь энэхүү үйл ажиллагааны хүрээнд тавигдах шаардлага, тэдгээртэй холбоотой өөрчлөлтийг тухай бүр нь ҮЦК болон ТГБ-нд бичгээр мэдэгдэнэ.
- 6.6. ТГБ болон ҮЦК нь “ҮЦТХТ” -тэй харилцах албан тушаалтныг томилж, өөрчлөгдсөн тохиолдолд тухай бүр “ҮЦТХТ” -д албан бичгээр мэдэгдэх үүрэгтэй.
- 6.7. ТГБ нь үнэт цаасны арилжааны төлбөр гүйцэтгэхдээ энэхүү журмыг мөрдлөг болгоно.
- 6.8. “ҮЦТХТ” нь энэхүү журамд заасны дагуу ТГБ-ны санхүүгийн хариуцлага, үйл ажиллагааны чадамж, туршлага болон мэргэжлийн түвшинг тогтоосон шалгуур үзүүлэлтийг хангахыг шаардана.
- 6.9. “ҮЦТХТ” нь ҮЦК болон ТГБ-ны санхүүгийн болон үйл ажиллагааны үзүүлэлт, “ҮЦТХТ” -өөс энэхүү журмаар тогтоосон шалгуур үзүүлэлт зэрэг нь шаардлагаас доогуур болсон тохиолдолд Хороо болон Монголбанкинд яаралтай мэдэгдэнэ.
- 6.10. ҮЦК болон ТГБ нь энэхүү журам болон тэдгээртэй байгуулсан гэрээг зөрчсөн тохиолдолд “ҮЦТХТ” нь уг гурвалсан гэрээний дагуу тэдгээрт хариуцлага оногдуулна.
- 6.11. МХБ-ээс тогтоосон гишүүнчлэлийн шалгуур үзүүлэлтийг ҮЦК хангаагүйг МХБ тогтоосон болон ҮЦТТХТ-ийн шалгуур үзүүлэлтийг ТГБ нь хангаагүй тохиолдолд тэдгээрийн “ҮЦТХТ” -ийн системд орох эрхийг түр зогсооно.

- 6.12. ҮЦК болон ТГБ нь нэг жилийн хугацаанд “ҮЦТХТ” -д тасралтгүй үйл ажиллагаа явуулаагүй, Хорооноос тусгай зөвшөөрлийг нь түдгэлзүүлсэн, хүчингүй болгосон болон ҮЦК нь МХБ-ийн гишүүнчэлээс хасагдсан тохиолдолд тэдгээртэй байгуулсан гэрээг цуцална.

Долдугаар зүйл. ТГБ-д тусгайлан тавигдах шалгуур

- 7.1. Монголбанкны зохистой харилцааны шалгуур үзүүлэлтийг сүүлийн 4 улиралд хангаж ажилласан, Монголбанкнаас үнэт цаасны төлбөр гүйцэтгэхэд татгалзах зүйлгүй гэх санал авсан арилжааны банкттай ТГБ-ны үйлчилгээ үзүүлэх гэрээг байгуулна.
- 7.2. Хүсэлт гаргагч нь эрх олгох үед болон олгосноос хойш энэхүү журмын 8.1.-д заасан санхүүгийн шаардлагуудыг тасралтгүй хангаж ажиллана.
- 7.3. Хүсэлт гаргагчийн удирдлага, гүйцэтгэх албан тушаалтнууд нь тухайн зах зээл, тооцоо хийх гэрээний мөн чанар, эрсдэл, түүнтэй холбоотой хүлээх үүргийн талаар хангалттай түвшний мэдлэгтэй, шударга зарчмыг хэрэгжүүлэх чадвартай байна.
- 7.4. Мөнгөн урсгал, санхүүжилтийн хэрэгцээгээ хянах, өдөр тутмын үйл ажиллагаанд зохих хөрвөх чадвараа хангах, арилжааны төлбөр гүйцэтгэх үүргээ биелүүлэхэд шаардагдах хангалттай тооны ажилтнууд, тоног төхөөрөмжтэй байх зэргээр цаг ямагт санхүүгийн хөрөнгө, хөрвөх чадварын өндөр шаардлагыг хангах нөөц, мэдээллийн технологи болон хяналтын системтэй байна.
- 7.5. “ҮЦТХТ”-өөс тухай бүр тавих шаардлага, шалгуурыг ТГБ нь ханган ажиллана.

Наймдугаар зүйл. ТГБ-ны заавал байлгах хөрөнгө, санхүүгийн нөөцийн доод хэмжээ

- 8.1. ТГБ дараах шаардлагыг цаг ямагт хангана:
- 8.1.1. 1-р зэрэглэлийн өөрийн хөрөнгийн хүрэлцээг “Банкны үйл ажиллагааны зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийг тогтоох, түүнд хяналт тавих журам”-д заасан хэмжээнд хадгалах;
- 8.1.2. Цаг үеийн шаардлагад нийцүүлэн Монголбанкнаас гаргасан арилжааны банкинд өөрийн хөрөнгийн хүрэлцээний шалгууртай нийцүүлэн тогтоосон шалгуурыг хангана;
- 8.1.3. “ҮЦТХТ” нь ТГБ-ийг сонгох болон шалгуур үзүүлэлтэд өөрчлөлт оруулах тохиолдолд МХБ-ээс санал авна;

Есдүгээр зүйл. ТГБ-ны үйл ажиллагаа

- 9.1. ТГБ нь “ҮЦТХТ” , ҮЦК-тай гэрээ байгуулан ажиллана.
- 9.2. ҮЦК нь харилцагчийн үнэт цаасны арилжааны мөнгөн төлбөрийг гүйцэтгүүлэх зорилгоор ТГБ-нд зөвхөн нэг тусгайлсан данс нээлгэнэ.
- 9.3. ТГБ нь үнэт цаасны төлбөр гүйцэтгэхтэй холбоотой харилцаанд зөвхөн МХБ-ийн төлбөрийн мэдээнд үндэслэн цэвэр дүнгээр төлбөрийг гүйцэтгэнэ.
- 9.4. ТГБ нь харилцагчийн үнэт цаасны төлбөрийн тусгайлсан данснаас харилцах ҮЦК-ийн зөвшөөрөлгүйгээр мөнгөн хөрөнгийн зарлагын гүйлгээ хийхийг хориглоно.

Аравдугаар зүйл. Монголбанкны шаардлагыг хангахгүй болсон ТГБ

- 10.1. “ҮЦТХТ” нь Монголбанкны шаардлагыг хангахгүй болсон ТГБ-нд дараах арга хэмжээг авч хэрэгжүүлнэ:

- 10.1.1. тус ТГБ-ны “ҮЦТХТ” -өөс зөвшөөрсөн аливаа төлбөрийн ажиллагааг гүйцэтгэх эрхийг даруй түдгэлзүүлнэ.
 - 10.1.2. “ҮЦТХТ” нь энэ журмын 19.1.1-д заасан арга хэмжээний тухай мэдэгдлийг монгол, англи хэл дээр үйлдэж, МХБ-тэй хамтран олон нийтэд цахим хуудсаар мэдээлнэ.
- 10.2. Дээр дурьдсан эрхийг түдгэлзүүлэх арга хэмжээнээс үл хамааран ТГБ нь бусдад төлөх мөнгөн төлбөрийн үүргээ үргэлжлүүлэн биелүүлэх үүрэгтэй.

Арваннэгдүгээр зүйл. Хариуцлагын тухай

- 11.1. ҮЦК болон ТГБ нь энэхүү журмыг зөрчсөн тохиолдолд тухайн зөрчил болон өмнө нь гаргаж байсан бусад зөрчлийн ноцтой байдлыг харгалзан “ҮЦТХТ” -өөс дор дурдсан арга хэмжээг авна:
- 11.1.1. албан шаардлага бичгээр хүргүүлнэ;
 - 11.1.2. хэрэв өмнө нь ийм төрлийн зөрчил гаргаж, “ҮЦТХТ” -өөс албан шаардлага бичгээр хүргүүлж байсан тохиолдолд “ҮЦТХТ” -ийн системд орох эрхийг түр зогсооно;
 - 11.1.3. ТГБ, ҮЦК-тай байгуулсан гэрээг цуцална;
 - 11.1.4. тухайн зөрчил бүрт гэрээнд заасны дагуу хариуцлагын арга хэмжээ авна;
- 11.2. “ҮЦТХТ” -өөс зөрчилд ногдуулах торгуулийн хэмжээг тогтоохдоо тус зөрчлийн ноцтой байдлыг харгалзан үзэх ба “ҮЦТХТ” -ийн системд оролцох эрхийг түр зогсоох, гэрээг цуцлах, ҮЦК-ийн тусгай зөвшөөрлийг түдгэлзүүлэх болон хүчингүй болгох үндэслэл бүхий хүсэлтийг Хороонд хүргүүлж, шийдвэрлүүлнэ.
- 11.3. ТГБ болон ҮЦК-ийн системд оролцох эрхийг түдгэлзүүлсэн болон цуцалсан (МХБ-ээр дамжуулан) тохиолдолд тэдгээр нь зөвхөн бусад ТГБ, ҮЦК болон харилцагчийн эрх ашгийг хамгаалахад зайлшгүй шаардлагатай гүйлгээг хийнэ.